## ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР АШИГЛАН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ

1. Доорх даалгавар алв түвшинд хамаарах вэ?

Цахилгаан шатанд $m$ = 80 кг масстай хүн суув. $g$=10 м/с$^2$
a. Цахилгаан шат эгц дээш жигд хурдаар хөдлөх үед хүний биеийн жин яагаад өөрчлөгддөггүй болохыгтайлбарлана уу.
b. Цахилгаан шат дээш 1 м/с$^2$ хурдатгалтай хөдлөх үед хүний биеийн жин яагаад нэмэгддэг болохыгтайлбарлан, тооцоолно уу.

A. Сонгох

B. Задгай

C. Холимог

D. Нарийвчлалтай

2. Нүүрс шатах үед энергийн аль хувирал явагддаг вэ?

A. Гэрлийн энерги дулааны энергид B. Химийн энерги дулааны энергид
C. Дотоод энерги механик энергид D. Потенциал энерги кинетик энергид
гэсэн даалгавар танин мэдэхүйн аль түвшинд орох вэ?

A. Сэргээн санах B. Ойлгох C. Хэрэглээ D. Үнэлэх

3. Үнэлгээ гэсэн ойлголтыг хамгийн оновчтой тодорхойлсон хариултыг сонгоно уу.
A. Багшийн сурагчдын тавьж буй дүнгийг үзүүлэлт
B. Багш ээлжит хичээлээ хэрхэн сайн заасныа үнэлж буй үзүүлэлт
C. Эзэмшсэн мэдлэг чадварыг илрүүлж буй үзүүлэлт
D. Даалгаврыг шалгаж үнэлгээ өгөх үзүүлэлт

4. Суралцахуйн үр дүнгийн шалгуурыг ямар түвшинд эзэмшсэнийг тодорхойлох илрэхийлэл .................... гэж үзнэ.

A. Гүйцэтгэлийн түвшин

B. Суралцахуйн үр дүнгийн шалгуур

C. Суралцахуйн үр дүн

D. Үнэлгээний нэгж

5. Гүйцэтгэлийн хүрэх V-VI түвшинд сурагчид ямар чадвар эзэмшсэн байх шаардлагатай гэж үздэг вэ?

A. Мэдлэгээ ойлгох B. Мэдлэгэ хэрэглээ болгох

C. Анализ, дүгнэл хийх D. Тайлбарлаж, мэдлэг бүтээх

LIVEWORKSHEETS